

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 6 АЖЛЫН ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦААГ
НИЙТ 14 УДАА СУНГАЖ, 2 АЖИЛ БҮРЭН ДУУСААГҮЙ, НИЙТ ТӨЛӨВЛӨСӨН
ҮР ДҮН 77.8 ХУВЬТАЙ БАЙНА.**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайлан**

АУДИТЫН КОД: ДОА-2026/05-9/ШТА-НА

Чойбалсан хот
2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нармандах
Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Аудитор С.Төмөрхуяг
Утас: 7058-4207, Цахим хаяг: tumurkhuyags@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....4

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ АВТОЗАМЫН АЖЛУУД ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ НЬ ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТИЙН АСУУДЛЫГ БҮРЭН ШИЙДВЭРЛЭЛГҮЙ ТӨЛӨВЛӨЖ, БАТАЛСНААС ШАЛТГААЛСАН БАЙНА.....5

1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулж, нэн тэргүүнд хэрэгцээ, шаардлагатай төсөл, арга хэмжээг тодорхойлж төлөвлөх эрх зүйн орчин орон нутагт бүрдээгүй байна.....5

1.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх автозамын ажлууд гэрээний хугацаандаа хэрэгжээгүй нь газар чөлөөлөлтийн асуудлыг бүрэн шийдвэрлэлгүй төлөвлөж, баталснаас шалтгаалсан байна.....6

БҮЛЭГ 2. БАЯН-УУЛ СУМЫН ЕБС-ИЙН ДОТУУР БАЙРНЫ БАРИЛГЫН ГАДНА ШУГАМЫН АЖЛЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХИЙГ САНГИЙН ЯАМНААС ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААГ ХОЦРООН ШИЛЖҮҮЛСЭН БАЙНА.....7

2.1 Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны барилгын гадна шугамын 420.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг сангийн яамнаас хуульд заасан хугацааг хоцроон аймгийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн байна.....7-8

2.2 Сангийн яамнаас тендер шалгаруулалттай холбоотой нэг гомдлыг хуулийн хугацаанд хянаж, шийдвэрийг цахим сайтад мэдээлсэн байна.....9

БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 6 АЖЛЫН ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦААГ НИЙТ 14 УДАА СУНГАЖ 2 АЖИЛ БҮРЭН ДУУСААГҮЙ НИЙТ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮН 77.8 ХУВЬТАЙ БАЙНА.10

3.1 Автозамын хийгдээгүй 4 ажилд гүйцэтгэл бичиж 379.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна..... 10-13

3.2 Хөрөнгө оруулалтын ажлын чанар, гүйцэтгэлтэй холбоотой алдаа, зөрчил гарч байгаа нь захиалагчийн хяналтыг чанаргүй хэрэгжүүлснээс шалтгаалсан байна.....14-16

3.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 4,658.7 сая төгрөгийн авто замыг санхүүгийн бүртгэл, тайланд тусгаагүй байна.....16-20

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....20
 ДҮГНЭЛТ:21
 САНАЛ:21
 ЗӨВЛӨМЖ:22
 АЛБАН ШААРДЛАГА.....23-26
 ТУШААЛ.....27-28

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын стандарт
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НА	Нийцлийн аудит
ШТА	Шууд тайлагнах аудит
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАтХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Тендер шалгаруулалтын зааварчилгаа
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
MNS	Mongolian national standard
УХТО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт

	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p>
<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаалыг үндэслэн хийлээ.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх; • Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх; • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитад Дорнод аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 2025 онд хэрэгжүүлэхээр шилжүүлсэн төсөл, арга хэмжээ болон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, сумдын Засаг дарга захиалагч байгууллагууд, хяналт хэрэгжүүлсэн байгууллагууд, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудитыг гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер Д.Нармандах аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг, С.Төмөрхуяг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.</p> <p>Аудитын дэд төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдөр батлуулж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 4 дүгээр сарын 29-ний өдрөөс 5 дугаар сарын 04-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 5 дугаар сарын 07-ны өдөр ҮАГ болон холбогдох байгууллагад хүргүүлжээ.</p>

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ АВТОЗАМЫН АЖЛУУД ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ НЬ ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТИЙН АСУУДЛЫГ БҮРЭН ШИЙДВЭРЛЭЛГҮЙ ТӨЛӨВЛӨЖ, БАТАЛСНААС ШАЛТГААЛСАН БАЙНА.

1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулж, нэн тэргүүнд хэрэгцээ, шаардлагатай төсөл, арга хэмжээг тодорхойлж төлөвлөх эрх зүйн орчин орон нутагт бүрдээгүй байна.

1.1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт эрх шилжиж ирсэн авто замын 9 төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8¹, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3²-т заасан шаардлагад нийцэхгүй байна.

ҮАГ-т уламжилж нэгтгэсэн тайланд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлах аудитын шийдвэрийг Сангийн яаманд хүргүүлэх.

1.1.2 Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 1/1430 дугаар албан бичгээр орон нутагт хэрэгжүүлэх шаардлагатай Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг Сангийн яаманд хүргүүлсэн байна. Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал"-аар барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг зөвхөн үнэлж эрэмбэлж байгаа бөгөөд их засварын ажил, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, ач холбогдол зэрэг шалгуураар үнэлж, эрэмбэлж төлөвлөх асуудлыг хууль, журмаар зохицуулаагүй байна.

ҮАГ-т уламжилж нэгтгэсэн тайланд их засвар, тоног төхөөрөмжийн ангилалд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль, журамд тусгуулах аудитын шийдвэрийг Сангийн яаманд хүргүүлэх.

1.1.3 Дорнод аймгийн Засаг даргын 2024 оны 1/2528 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайдад Монгол Улсын 2025 оны төсвийн хөрөнгөөр ТЭЗҮ, зураг төсөв хийгдэх шаардлагатай 13 төслүүдийг хүргүүлсэн боловч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээг Улсын 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд огт батлаагүй байна.

¹ Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх;

² улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

ҮАГ-т уламжилж нэгтгэсэн тайланд орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах хөрөнгө оруулалтын зураг, төсөв хийгдэх шаардлагатай зардлыг батлахад анхаарч ажиллах аудитын шийдвэрийг Сангийн яаманд хүргүүлэх.

1.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх автозамын ажлууд гэрээний хугацаандаа хэрэгжээгүй нь газар чөлөөлөлтийн асуудлыг бүрэн шийдвэрлэлгүй төлөвлөж, баталснаас шалтгаалсан байна.

1.2.1 Аймгийн төв Хэрлэн сум доторх хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/, Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт багц 6 /Музейн уулзвараас шинээр төлөвлөгдөж буй 1800 айлын хотхон, хороолол хүртэлх авто зам 440 метр/ Эдгээр 2 замын трасс нь айлын өмчлөлийн газартай давхцуулан төлөвлөсөн байна.

1.2.2 Автозамын ажлыг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх гэсэн төлөвлөлтийн шаардлага хангаагүйгээс шалтгаалан дараах 2 ажлын гэрээг сунгах шаардлага үүссэн байна.

- Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/ ажлын гүйцэтгэгч гэрээний хугацааг сунгуулсан.

- "Музейн уулзвараас шинээр төлөвлөж буй 1800 айлын хотхон хороолол хүртэлх авто зам"-ын багц 6: гүйцэтгэгч авто замын трасс, зураг төслийг өөрчлөх шаардлага үүссэнээс гэрээний хугацааг сунгуулсан.

Энэ нь Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Захиалагч нь авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, саадгүй хэрэгжүүлэхэд шаардагдах зураг төсөл, замын чиг /трасс/, геодезийн цэгүүд, газар эзэмшүүлэх зөвшөөрөл зэргийг гүйцэтгэгчид хүлээлгэн өгч, авто замын барилгын ажил явуулах талбайг чөлөөлөх асуудлыг шийдвэрлэсэн байна." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2.3 Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтад хүргүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан тэнцүү хуваарилж төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 "шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;" гэсэн заалттай нийцсэн байна.

1.2.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт эрх шилжиж ирсэн авто замын 9 төсөл, арга хэмжээг 2024, 2025 онд хэрэгжиж дуусахаар төлөвлөж хуваарилсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 "шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;" гэсэн заалттай нийцсэн байна.

1.2.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөлтийн шаардлага хангахгүй ажлыг хэрэгжүүлэхээр баталсан нь Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт багц 2, Хүүхэд, эмэгтэйчүүдийн гудамж, Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт багц 6, Музейн уулзвараас шинээр төлөвлөгдөж буй 1800 айлын хотхон, хороолол хүртэлх авто замын ажлууд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар баталсан хугацаанд бүрэн хэрэгжиж ашиглалтад ороогүй байна.

БҮЛЭГ 2. БАЯН-УУЛ СУМЫН ЕБС-ИЙН ДОТУУР БАЙРНЫ БАРИЛГЫН ГАДНА ШУГАМЫН АЖЛЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХИЙГ САНГИЙН ЯАМНААС ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААГ ХОЦРООН ШИЛЖҮҮЛСЭН БАЙНА.

2.1 Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны барилгын гадна шугамын 420.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг сангийн яамнаас хуульд заасан хугацааг хоцроон аймгийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн байна.

2.1.1 Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 44 дүгээр тушаалаар Шинээр ашиглалтад орсон дотуур байрны барилгын гадна шугамын ажил /Дорнод, Баян-Уул сум 420.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ/-ын эрх Дорнод аймгийн Засаг даргад шилжсэн байна.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025.03.14-ний өдрийн 02/1748 дугаартай албан бичгээр Сангийн сайдын 2025.02.27-ны өдрийн 44 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах тухай мэдэгдсэн байна. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2025.04.09-ний өдөр оруулсан байна.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025.03.14-ний өдрийн 02/1748 дугаартай албан бичгээр Сангийн сайдын 2025.02.27-ны өдрийн 44 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах тухай мэдэгдсэн байна. Гэвч төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2025.04.09-ний өдөр буюу Сангийн сайдын 2025 оны 44 дүгээр тушаалаас 30 хоногийн дараа шилжүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7-д "Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1з, 45.2а, 45.3б, 45.4б-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн

3 45.1.Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад тусгагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч байна.

4 45.2.Энэ хуулийн 45.1-д заасан төсөл, арга хэмжээний жагсаалтыг дараа оны төсвийн тухай хууль албан ёсоор нийтлэгдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор Засгийн газар батална.

5 45.3.Энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна.

6 45.4.Энэ хуулийн 45.1, 45.2, 45.3-т зааснаас бусад улсын төсвийн хөрөнгө, захиалагчийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг захиалагч өөрөө зохион байгуулна.

байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Дорнод аймагт 2024-2025 онд улсын төсвөөс эрх шилжин ирж, он дамжин үргэлжилж байгаа авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Зам тээврийн яамнаас Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолоор тогтоосон хугацаанаас 33 хоног хоцроож Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн талаар өмнөх аудитын тайланд бичигдэж байсан. Энэ зөрчил жил дараалан давтагдан гарч байна.

ҮАГ-т уламжилж нэгтгэсэн тайланд "хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг ТБОНӨХБАҮХАТХ-д заасан хугацаанд цахимаар шилжүүлж байх" гэсэн аудитын шийдвэрийг тусгуулахаар хүргүүлэх.

2.1.2 Дорнод аймагт эрх шилжиж ирсэн "Шинээр ашиглалтад орсон дотуур байрны барилгын гадна шугамын ажил /Дорнод, Баян-Уул сумын 420.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ/-ын худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог аймгийн Засаг дарга 2025.04.16-ны өдөр А/251 дүгээр захирамжаар байгуулсан байна. Аймгийн Засаг даргаас Худалдан авах ажиллагааны газарт дээрх ажлын зураг, төсвийг хугацаанд нь шилжүүлж ажилласан байна.

2.1.3 Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шинээр ашиглалтад орсон дотуур байрны барилгын гадна шугамын ажил /Дорнод, Баян-Уул сумын 420.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ/-ын тендер шалгаруулах үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлээр тендерийн баримт бичигт дараах зүйлсийг нэмж оруулсан байна.

Үүнд:

- Борлуулалтын орлогын хэмжээ 2022, 2023, 2024 онуудын дундаж нь батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх,
- Банк санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй байх,
- Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт,
- Барилга хот байгуулалтын яамнаас олгодог БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт хийх тусгай зөвшөөрөл,
- Мөн машин, механизмын хүчин чадал, тоо ширхэг, инженер, техникийн ажилчдын тоо, ажлын туршлага, мэргэжлийг тусгаж оруулсан байна.

2.1.4 "Шинээр ашиглалтад орсон дотуур байрны барилгын гадна шугамын /Дорнод, Баян-Уул сумын 420.5 сая төгрөгийн/ ажил улсын төсөвт тусгагдсан ч төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2025.04.09-ний өдөр хугацаа хоцроон Дорнод аймгийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн мөн тендер шалгаруулалтад оролцогчоос Сангийн яаманд гомдол гаргаж, гомдлын хариу 2025.06.04-ний өдөр гарсан зэргээс шалтгаалан Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаа хэтэрсэн тул тендер шалгаруулах үйл ажиллагаа цуцлагдсан байна.

2.1.5 Улсын төсвөөс Дорнод аймагт 2025 онд эрх шилжиж ирсэн "Шинээр ашиглалтад орсон дотуур байрны барилгын гадна шугамын /Дорнод, Баян-Уул сумын 420.5 сая төгрөгийн/ ажил дээрх шалтгаанаар цуцлагдсан тул гүйцэтгэгч шалгараагүй.

2.2 Сангийн яамнаас тендер шалгаруулалттай холбоотой нэг гомдлыг хуулийн хугацаанд хянаж, шийдвэрийг цахим сайтад мэдээлсэн байна.

2.2.1 Тайлант хугацаанд "Шинээр ашиглалтад орсон дотуур байрны барилгын гадна шугамын ажил /Дорнод, Баян-Уул сумын 420.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээ/-ын сонгон шалгаруулалтад "Дорнын үндэс" ХХК шалгарч, гэрээ байгуулах эрхийг тус компанид 2025.05.14-ний өдрийн 1/1211 дугаартай албан бичгээр хүргүүлсэн байна.

"Дорнын оч" ХХК-аас Сангийн яаманд гомдол гаргаснаар 2025.05.23-ны өдрийн 02/4704 дугаартай албан бичгээр тендер шалгаруулалтыг түдгэлзүүлсэн байна. Сангийн яамнаас гомдлыг хянаад 2025.06.04-ний өдрийн 02/5424 дугаартай албан бичгээр "тендер шалгаруулалт хууль, журмын дагуу зохион байгуулагдсан байна" гэх хариуг ирүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.87-д заасан ажлын 10 өдөрт багтаан гомдлыг хянаж шийдвэрлэнэ. гэж заасан хугацаанд шийдвэрлэсэн байна.

2.2.2 Тайлант хугацаанд шинээр ашиглалтад орсон дотуур байрны барилгын гадна шугамын ажил /Дорнод, Баян-Уул сумын 420.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээ/-ын сонгон шалгаруулалтад "Дорнын оч" ХХК-аас гаргасан гомдлын хариуг Сангийн яамнаас 2025.06.04-ний өдөр ирүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн **05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах**" гэсэн хугацаанаас хэтэрсэн тул төсвийн хэмнэлтэд тооцогдож, уг ажил хэрэгжээгүй.

Сангийн яамны www.mof.gov.mn сайтын ил тод байдал, тендерийн гомдол, шийдвэрлэлт цэсийн 6 дугаар сарын тендер шалгаруулалтын гомдлын мэдээллийн дугаар 61 дүгээрт шинээр ашиглалтад орсон дотуур байрны барилгын гадна шугамын /Дорнод, Баян-Уул сумын 420.5 сая төгрөгийн/ ажилд "Дорнын оч" ХХК-ийн гаргасан гомдлыг бүхэлдээ үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн мэдээллийг байршуулсан байна.

БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 6 АЖЛЫН ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦААГ НИЙТ 14 УДАА СУНГАЖ, 2 АЖИЛ БҮРЭН ДУУСААГҮЙ, НИЙТ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮН 77.8 ХУВЬТАЙ БАЙНА.

3.1 Автозамын хийгдээгүй 4 ажилд гүйцэтгэл бичиж 379.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

7 59.8.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендер шалгаруулалтад холбоотой цахим системд байршуулсан баримт бичиг, мэдээлэл, тендер шалгаруулалтын хувийн хэрэгт үндэслэн гомдлын үндэслэлийн хүрээнд ажлын 10 өдөрт багтаан гомдлыг хянан шийдвэрлэнэ.

3.1.1 Дорнод аймагт 2024-2025 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 9 авто замын ажлуудаас багц 4, 5 дугаар авто замын барилгын ажлууд хугацаандаа хүлээлгэн өгсөн ч багц 1, 3, 4, 7 болон сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл 2.8 км, аймгийн төвийн хатуу хучилттай авто зам 5.5 км, **НИЙТ 6 авто замын ажлыг хүлээж авах хугацааг 14 удаа сунгасан байна.** Үүнд:

1. Газар чөлөөлөлттэй холбоотой

- Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/ ажлын гүйцэтгэгч 2 айлын газар нэмж чөлөөлөх болсонтой холбогдуулан гэрээний хугацааг сунгуулах хүсэлт тавьж сунгуулсан байна.
- “Музейн уулзвараас шинээр төлөвлөж буй 1800 айлын хотхон хороолол хүртэлх авто зам”-ын багц 6 дугаартай ажлын гүйцэтгэгч “Эм Эн Эйч Инженеринг” ХХК-аас 2025.10.03-ны өдрийн 2025/097 дугаартай албан бичгээр авто замын трасст 10 айлын өмчлөлийн газар давхцалтай тул авто замын трассыг өөрчлөх, зураг төслийг өөрчлөх шаардлага үүсэж хугацааг сунгуулсан байна. Уг ажил 39.9 хувийн гүйцэтгэлтэй он дамжсан байна.

2. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системтэй холбоотой

Гүйцэтгэгчээс ажлыг нь хүлээж авсан ч санхүүжилтийг Сангийн яамнаас олгох хүртэл, гэрээний хугацааг хүчинтэй байлгах, журамд заагаагүй шаардлага тавьж хийсвэрээр гэрээний хугацааг сунгуулж байна. Үүнд:

- Багц 1-ийн гүйцэтгэгч “Мянган тэмүүлэл” ХХК-аас 4 удаа сунгуулах хүсэлт ирүүлсэн гэрээт ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн бөгөөд Сангийн яамнаас санхүүжилт авах хүртэл гэрээний хугацааг сунгаж өгөх хүсэлт ирүүлсэн байна.
- Багц 3-ын гүйцэтгэгч “Эм Эн Эйч инженеринг” ХХК-аас 2025.08.30-ны өдрийн 2025/073 дугаартай албан бичгээр авто замын ажлыг гэрээний хугацаанд хүлээлгэн өгч, комиссын актаар баталгаажсан ч <https://pimis.publicinvestment.gov.mn/> программд санхүүжилт авах хүртэл хугацаанд гэрээний хугацааг сунгаж өгнө үү гэсэн хүсэлт ирүүлсэн байна.
- Багц 4-ийн гүйцэтгэгч “Баянцогт зам” ХХК-аас 2025.08.25-ны өдрийн №25-226 дугаартай албан бичгээр 2025.08.14-ний өдөр буюу гэрээний хугацаанд комисст хүлээлгэн өгсөн ч санхүүжилт авах хүртэл хугацаанд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем <https://pimis.publicinvestment.gov.mn/> -д гэрээний хугацаа дуусаагүй байх шаардлагатай тул гэрээний хугацааг сунгуулах хүсэлт ирүүлсэн байна.

Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-д гүйцэтгэлийг хүлээж авсан комиссын акт гарсан ч санхүүжилт олгох хүртэл гэрээний хугацаа хүчинтэй байх талаар тусгагдаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1-т “захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах,” гэсэн заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын нэгтгэсэн тайланд санхүүжилт авах хүртэл гэрээний хугацаа хүчинтэй байх

гэсэн журамд тусгаагүй шаардлага www.pimis.publicinvestment.gov.mn систем тавьж байгааг өөрчлөлт оруулах талаар санал хүргүүлэв.

Багц 2-ын авто замын ажил 63.9 хувийн гүйцэтгэлтэй он дамжсан бөгөөд гэрээнд заасан хугацаанд хэрэгжүүлээгүй байна. Энэ нь асфальтбетон оройтсон болон зураг төсөвт тусгагдаагүй газар доорх дулааны шугам хоолой авто замын трасстай огтлолцсон зэргээс шалтгаалсан байна.

Багц 5-ын гүйцэтгэгч “Булган өндөр” ХХК нь гэрээний хугацаанд хүлээлгэн өгч сунгалт хийлгэлгүй дуусгасан байна.

Багц 7-ын ажлын гүйцэтгэл 98 хувь бөгөөд 80 метр квадрат явган хүний авто замыг үүрэг даалгаврын биелэлтээр хэрэгжүүлэхээр хүлээлгэн өгсөн байна. Бусад авто замын ажлуудыг үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан байна.

3.1.2 Авто замын 4 ажлын бодит гүйцэтгэлийг үнэлээгүй 379.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн авто замын төсөл, арга хэмжээнүүдээс 2025 онд хүлээж авсан 7 авто замын ажил бүгд үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан байна. Энэ нь тодорхой ажлуудыг сайжруулах, дутуу байгааг нөхөж хийх хугацаатай албан даалгаврыг гүйцэтгэгчид өгсөн байна.

Бодит гүйцэтгэлийг үнэлээгүй 4 ажилд 379.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- Багц 6: Хэрлэн сумын 3 дугаар баг, аймгийн Музейн уулзвараас шинээр төлөвлөж буй 1800 айлын хотхон, хороолол хүртэлх авто замд хашлага хийгдээгүй байхад хашлага суурилуулах, суурь байгуулах ажлын 51.0 сая төгрөгийг олгосон байна.
- Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/ ажлын гүйцэтгэлд 3,526.0 метр квадрат зүлэгжүүлэлт олон наст ургамлын үрд 2.8 сая төгрөг зарцуулсан гэсэн төсвийн тооцоог ирүүлсэн байна. Зүлэгжүүлэлт хийгдээгүй, газар чөлөөлөлт хийгдээгүй хэсэгт явган хүний замын ажилд 13.7 сая санхүүжилтийг олгосон байна.
- Багц 2: Явган хүний зам дутуу хийгдсэн, авто замын тоноглолын ажил замын тэмдэглэгээг зориулалтын машинаар термопластик будгаар хийх 76.5 сая төгрөг, хөтөч хавтанг термопластик будгаар хийх 235.4 сая төгрөгийн ажлууд хийгдээгүй байхад санхүүжилтийг олгосон.
- Багц 7: Явган хүний зам 80 метр квадрат зам дутуу хийгдсэн байхад үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон байна. Ажлын гүйцэтгэл 98 хувь байна.

Гүйцэтгэл илүү бичиж санхүүжилт авсан нь авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг бодитоор хэрэгжүүлээгүй мөн тухайн төсвийн жилдээ багтаж гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохгүй бол санхүүжилт буцаан татагддаг гэх шалтгаанаар гүйцэтгэл дутуу санхүүжилтийг олгосон байна.

3.1.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй авто замын 5 ажил байна.

Зураг төсвийн төлөвлөлт буруу, захиалагчийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлсэн ч үр дүн хангалтгүй. Ажлыг бүрэн дуусаагүй байхад улсын комисс үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авсан.

Газар чөлөөлөлт болон замын трасс дагуух барилга, байгууламжийг чөлөөлөх эсэх асуудлыг шийдвэрлэсний дүнд зураг төсвийг батлахгүйгээр ажлын явцад газрыг чөлөөлүүлнэ гэж төлөвлөн ажлыг эхлүүлснээр хуулиар баталсан хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй, зураг төсөв өөрчлөгдөх шалтгаан болж байна.

Автозамын ажлыг газар дээр нь очиж үзэхэд дараах ажлуудыг зураг төсвөөс зөрүүтэй гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Багц 2: "Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамж" автозамын мянгат хорооллын араар замын төгсгөл хэсэгт автомашины граж дагуух явган зам, авто зогсоолыг хасаж өөр газарт шилжүүлсэн, бродюрыг хэвтүүлж байрлуулсан.

2. Музейн уулзварын зам анх гарсан зургаас өөрчлөгдөж 42 метр сунгахаар болж төсөвт зардал 372.9 сая төгрөгөөр нэмэгдсэнд дахин тендер зарлаж Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд тусгасан байна.

3. Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/ замын тодорхой хэсэгт явган зорчигчийн замыг бүрэн тавиагүй, анхны зураг төсөвт замын хавтангаар тавихаар тусгасан ч гүйцэтгэлийн явцад асфальтан хучилттай болгож өөрчилсөн. Зам дагуух 221 метр квадрат явган хүний зам, 120 метр явган хүний замын хашлага буюу нийт 13.7 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй.

4. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 1: Баянтүмэний гудамж замын бродюрт байрлах ус зайлуулах нүх газраас өндөр түвшинд байрласан нь ус зайлуулах суваг руу ус орох боломжгүй байна. Харааны бэрхшээлтэй хүний зорчих хэсгийн эхлэл болон төгсгөлийг буруу байрлуулсан.

5. Багц 7: Цагдаагийн газрын баруун талаар хойш 1 км үргэлжлэх замын төгсгөл хэсэгт 31.9 сая төгрөгийн 80 метр квадрат явган замын ажил, 2195 метр квадрат хэвтээ тэмдэглэгээний ажлыг хийж гүйцэтгээгүй. /Үүрэг даалгаврын биелэлтээр улсын комисст хүлээн авсан ч хэрэгжүүлээгүй байна./ Мөн тус замын төгсгөл хэсэгт асфальтан хучилт чанарын шаардлага хангаагүй нимгэн дэвссэн, суулт өгсөн, хагарсан, явган хүний хөтөч хавтанг зургийн дагуу гүйцэтгээгүй. Замыг улсын комисст хүлээж авах үеийн үүрэг даалгаврын биелэлтэд хуучин гэрлийн шонгийн нүхийг явган замын хавтангаар дүүргэхээр тусгасан ч газар дээрх хяналтын үед тус ажлыг гүйцэтгээгүй байна.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан замуудын 45.6 сая төгрөгийн гүйцэтгээгүй ажлуудыг чанарын баталгааны хугацаанд гүйцэтгүүлж дуусгах албан шаардлага өгөв.

3.1.4 Төсөл, арга хэмжээг гэрээний хугацааны дагуу гүйцэтгээгүйгээс шалтгаалж багц 2, багц 6 замуудын 1,121.1 сая төгрөгийн санхүүжилт Улсын төсөвт буцаан татагдсан. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд буцаан татагдсан санхүүжилтийг оруулж батлаагүй байна.

Анх байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг сунгасан дараах ажлууд байна.

Хүснэгт 1.

№	Төсөл, арга хэмжээний нэр	Анхны гэрээ дуусах хугацаа	Гэрээ сунгасан тоо
1	Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/	2025.10.30	1
2	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5.5 км /Дорнод, Хэрлэн сум/	2025.03.29	1
3	Багц 1. Баянтүмэний гудамж /Баянтүмэний гудамжны авто замын хашлагыг шинэчлэх, ус зайлуулах суваг хоолойн ажил/	2025.06.28	3
	Багц 2. Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамжны авто замаас Мянгат хороолол чиглэлийн хатуу хучилттай авто зам (Хэрлэн сум 7 дугаар баг)	2025.06.25	зогссон
	Багц 3. Содномдаржаагийн гудамжны 0.46 км босоо тэнхлэгийн авто зам Дорнод аймаг	2025.05.01	2
	Багц 4. Дорнод аймаг, Хэрлэн сум Хянганы гудамжны 0.96 км авто замын барилгын ажил	2025.08.25	1
	Багц 6. Дорнод аймаг, Хэрлэн сумын 3 дугаар баг, аймгийн Музейн уулзвараас шинээр төлөвлөгдөж буй 1800 айлын хотхон, хороолол хүртэлх авто зам	2025.11.30	зогссон
НИЙТ	Багц 7. Дорнод аймаг, Хэрлэн сум, Данриг Данжайлин хийдийн баруун урд уулзвараас эхлэн Цагдаагийн баруун талаар хойд чиглэлд үргэлжлэх 0.961 км авто зам	2025.08.16	3

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Хуулийн хугацаандаа ашиглалтад ороогүй дараах ажлууд байна.

1. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 2: Хүүхэд, эмэгтэйчүүдийн гудамж гүйцэтгэл 64.3 хувьтай.

2. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 6 Дорнод аймаг, Хэрлэн сумын 3 дугаар баг, аймгийн Музейн уулзвараас шинээр төлөвлөгдөж буй 1800 айлын хотхон, хороолол хүртэлх авто зам гүйцэтгэл 39.9 хувьтай.

Гүйцэтгэл дутуу байгаа багц 2 Хүүхэд, эмэгтэйчүүдийн гудамж, багц 6 Дорнод аймаг, Хэрлэн сумын 3 дугаар баг, аймгийн Музейн уулзвараас шинээр төлөвлөгдөж буй 1800 айлын хотхон, хороолол хүртэлх авто замуудыг бүрэн ашиглалтад оруулах ажлыг шат дараатай зохион байгуулах зөвлөмж өгөв.

3.2 Хөрөнгө оруулалтын ажлын чанар, гүйцэтгэлтэй холбоотой алдаа, зөрчил гарч байгаа нь захиалагчийн хяналтыг чанаргүй хэрэгжүүлснээс шалтгаалсан байна.

3.2.1 Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж, акт, фото зургаар баталгаажуулж ажилласан ч захиалагчийн хяналтаар талбайн зааварчилгааны үеэр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй, автозамын төгсгөл хэсэгт асфальтан хучилт чанарын шаардлага хангахгүй байна.

Багц 7: Цагдаагийн газрын баруун талаар хойш 1км үргэлжлэх замын төгсгөл хэсэгт асфальтан хучилт чанарын шаардлага хангаагүй нимгэн дэвссэн, суулт өгсөн, хагарсан, явган хүний хөтөч хавтанг зургийн дагуу гүйцэтгээгүй. Танил санаа ХХК-ийн зүгээс талбайн зааварчилгааны үеэр хучилтын гадаргын зохих хэсэг хотгор болж, тэгш байдал алдагдсан байгаа тул өгсөн зааварчилгааны дагуу 2025.10.15-2025.10.24-ны хооронд хийж гүйцэтгэх зааварчилгааг өгсөн байна. /Зөвлөхийн тайлан №03/

3.2.2 Улсын төсвөөс 2025 онд хэрэгжүүлсэн автозамын ажлуудаас асфальтан хучилт хийсэн замуудад “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Авто замын

итгэмжлэгдсэн төв лабораторид далан суурийн шинжилгээг хянан баталгаажуулж, дэвссэн асфальтан хучилтаас өрөмдөн /кор/ дээж авч зузааныг хэмжиж ажилласан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн 9 автозамын ажлаас 3 автозам нь 2024 онд асфальтан хучилтаа авсан бөгөөд тус замуудад Төрийн аудитын байгууллагыг төлөөлөн ажилласан мэргэжлийн шинжээч нар асфальтын дээжийг авч мэргэжлийн лабораторид шинжлүүлж, гүйцэтгэгч байгууллагын шинжилгээтэй харьцуулсан дүгнэлт, шийдвэр гаргаж ажилласан. 2025 онд асфальтан хучилт хийсэн 4 автозамын асфальтан хучилтаас дээж авч “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Авто замын итгэмжлэгдсэн төв лабораторид далан суурийн шинжилгээг хянан баталгаажуулсан байна. Мөн дэвссэн асфальтан хучилтаас өрөмдөн /кор/ дээж авч зузааныг хэмжиж ажилласан байна.

Замын чанар байдалтай холбоотой дараах зөрчлүүд гарсан. Үүнд:

1. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 7 Дорнод аймаг, Хэрлэн сум, Данриг Данжайлин хийдийн баруун урд уулзвараас эхлэн Цагдаагийн баруун талаар хойд чиглэлд үргэлжлэх 0.961 км автозам.
 - Замын төгсгөл хэсэгт асфальтбетон хучилт чанарын шаардлага хангаагүй нимгэн дэвссэн, суулт өгсөн, хагарсан. Асфальтбетон хучилтын нягт хүрээгүй дутуу нягтруулсан
 - Явган хүний хөтөч хавтанг зургийн дагуу гүйцэтгээгүй.
 - Замыг улсын комисст хүлээж авах үеийн үүрэг даалгаврын биелэлтэд хуучин гэрлийн шонгийн нүхийг явган замын хавтангаар дүүргэхээр тусгасан ч газар дээрх хяналтын үед тус ажлыг гүйцэтгээгүй байна.
 - Гадаргуу тэгш бус хийгдсэн байна.
2. Баянтүмэний гудамжны авто замын хашлагыг шинэчлэх, ус зайлуулах суваг хоолойн ажил
 - Борооны ус зайлуулах нүхтэй хашлагуудын нүхний тэгш хэм алдагдсан. /Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт аудитын хүрээнд Төрийн аудитын байгууллагыг төлөөлөн ажилласан шинжээчдийн зүгээс газар дээрх хяналтын үеэр засаж сайжруулахыг зөвлөсөн ч бүрэн хэрэгжүүлээгүй байна./

Хөрөнгө оруулалтын ажлын чанар, гүйцэтгэлтэй холбоотой алдаа, зөрчил гарч байгаа нь захиалагчийн хяналтыг чанаргүй хэрэгжүүлснээс шалтгаалсан байна.

Дорнод аймгийн Засаг даргад чанарын хяналтын хугацаанд зөрчлийг арилгаж, төсөл, арга хэмжээг чанартай гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах албан шаардлага өгөв.

3.2.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт эрх шилжиж ирсэн автозамын 9 ажлаас 7 автозамыг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, 2 автозамын санхүүжилт татагдсан ажил зогсолтын байдалтай байна.

Багц6 аймгийн Музейн уулзвараас шинээр төлөвлөгдөж буй 1800 айлын хотхон, хороолол хүртэлх авто замын трасс дагуу байрлах айлуудын газар чөлөөлөлтийн асуудал шийдэгдээгүй байхад ажлыг эхлүүлснээс болж зураг төсөлд өөрчлөлт орж, санхүүжилт буцаан татагдсан, гүйцэтгэл дутуу байна.

Тухайн төсвийн жилдээ багтаж гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохгүй бол санхүүжилт буцаан татагддаг гэх шалтгаанаар гүйцэтгэл дутуу санхүүжилтийг олгодог, бүрэн дуусаагүй ажлыг үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авдаг байна.

Үүрэг даалгаврын биелэлтээр авсан ажлуудыг бүрэн гүйцээж хийгээгүй байна. Үүнд:

1. Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/ зам дагуух 221м² явган хүний зам, 120м явган хүний замын хашлага буюу нийт 13.7 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй.

2. Данриг данжаалин хийдээс цагдаагийн баруун талын зам дээр явган хүний зам дутуу /төгсгөл хэсэгт асфальт хучилт эвдэрсэн, явган замын хөтөч хавтан тавих хэсэгт төгсгөл хавтангаар хийсэн, гэрлийн шонг байрлуулахдаа хуучин гэрлийн шонгийн суурийг ил үлдээсэн, 31.9 сая төгрөгийн 80м² явган замын ажил, 2195м² хэвтээ тэмдэглэгээг дутуу гүйцэтгэсэн. Гэрлийн шонгууд явган хүний замыг голлож, харааны бэрхшээлтэй хүний явах хэсэгт байрласан.

3. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц1 Баянтүмэний гудамж замын бродюрт байрлах ус зайлуулах нүх газраас өндөр түвшинд байрласан нь ус зайлуулах суваг руу ус орох боломжгүй байна. Харааны бэрхшээлтэй хүний зорчих хэсгийн эхлэл болон төгсгөлийг буруу байрлуулсан.

Дорнод аймгийн Засаг даргад үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан замуудын 45.6 сая төгрөгийн гүйцэтгээгүй ажлуудыг чанарын баталгааны хугацаанд гүйцэтгүүлж дуусгах албан шаардлага өгөв.

3.2.4 Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг байршуулаагүй байна. Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн /Захиалагчийн чиг үүрэг/ 37.1.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.10⁸, 8.6.11⁹-д заасны дагуу барилга байгууламж болон үйл ажиллагааныхаа талаарх иж бүрэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байрлуулах гэж заасны дагуу захиалагч нь Монгол Улсын үндэсний стандарт /MNS 7023:2023/-ыг баримтлан мэдээллийг иж бүрэн нээлттэй байршуулах үүргийг хүлээнэ.

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн С/49 дүгээр тушаалаар баталсан ангилалтын код 01.080.10 стандартын 6.6-т “хэрэгжилтээс хамаарч иргэдийн зорчих хэсэгт өөрчлөлт орох бол орчны мэдээлэл, эргэх чиглэлд иргэдэд ойлгомжтой, чирэгдэлгүй, шуурхай байдлаар замын босоо тэмдгийг нэмж байршуулна. Энэ нь барилга угсралт болон тохижилт, засварын ажлаас бусад трасс бүхий ажилд хамаарна”, 6.7-т “Мэдээллийн самбарыг трасс бүхий ажлын эхлэл, төгсгөлд нийтэд харагдахуйц ил тод байршуулна” гэж заасан байдаг.

8 8.6.10.мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;

9 8.6.11.барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн, дүгнэлт;

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд Дорнод аймагт хэрэгжүүлсэн автозамуудын мэдээллийн самбарыг трасс бүхий ажлын эхлэл, төгсгөлд нийтэд харагдахуйц ил тод байршуулах ажил хийгдээгүй байна.

Дорнод аймгийн Засаг даргад захиалагчийн чиг үүргийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн С/49 дүгээр тушаалаар баталсан стандартын дагуу мэдээллийг ил тод байрлуулах зөвлөмж өгөв.

3.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг санхүүгийн бүртгэл, тайланд тусгаагүй байна.

3.3.1 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэх тогтоол, шийдвэр гаргаагүй, нийт 4,658.7 сая төгрөгийн замыг бүртгэл, тайланд тусгаагүй байна. Үүнд:

- 4,092.7 сая төгрөгийн 3 замыг тусгаагүй.
- 566.0 сая төгрөгөөр 1 замыг дутуу тусгасан.

"Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.2.2.4-т "Барилга байгууламж, өргөтгөл, их засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсны үндсэн дээр эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлт гаргах бөгөөд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх мэдээллийг цахим системд баталгаажуулсан байх,"

Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1 дэх заалт: Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад хүлээж авсан замуудаас хөрөнгөөр бүртгээгүй дараах замууд байна.

Хүснэгт 2.

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн /сая төгрөг/	Хөрөнгөөр бүртгэсэн дүн	Гүйцэтгэл хувь
1	Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/	8,736.3	8,736.3	100%
2	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5.5 км /Дорнод, Хэрлэн сум/	3,889.0	3,889.0	100%
3	Багц 1. Баянтүмэний гудамж /Баянтүмэний гудамжны авто замын хашлагыг шинэчлэх, ус зайлуулах суваг хоолойн ажил/	919.6	919.6	100%
	Багц 2. Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамжны авто замаас Мянгат хороолол чиглэлийн хатуу хучилттай авто зам (Хэрлэн сум 7 дугаар баг)	1,569.5	Дуусаагүй	64.3%
	Багц 3. Содномдаржаагийн гудамжны 0.46 км босоо тэнхлэгийн авто зам Дорнод аймаг	993.1	Бүртгээгүй	100%
	Багц 4. Дорнод аймаг, Хэрлэн сум Хянганы гудамжны 0.96 км авто замын барилгын ажил	1,786.0	Бүртгээгүй	100%
	Багц 5. Хэрлэн сум, Эмнэлгийн бүсийн 0.58 км авто замын барилгын ажил	1,313.6	Бүртгээгүй	100%

	/Дорнод, Хэрлэн сум/	Багц 6. Дорнод аймаг, Хэрлэн сумын 3 дугаар баг, аймгийн Музейн уулзвараас шинээр төлөвлөгдөж буй 1800 айлын хотхон, хороолол хүртэлх авто зам	932.8	Дуусаагүй	39.9%
		Багц 7. Дорнод аймаг, Хэрлэн сум, Данриг Данжайлин хийдийн баруун урд уулзвараас эхлэн Цагдаагийн баруун талаар хойд чиглэлд үргэлжлэх 0.961 км авто зам	1,596.4	1,030.4	100%
	НИЙТ		21,736.3	14,575.3	85.5%

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам 5.5 км /Дорнод, Хэрлэн сум/, Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/, Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 1: Баянтүмэний гудамж төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон автозамуудыг хөрөнгөөр бүртгэж санхүүгийн тайланд тусгасан байна.

УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон дараах замуудыг ашиглагч тал орлогоор бүртгээгүй байхад сүүлийн санхүүжилтийг олгосон байна.

1. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 3: Содномдаржаагийн гудамжны 0.46 км авто замыг хөрөнгөөр бүртгээгүй. 993.1 сая төгрөг.
2. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 4: Хянганы гудамжны 0.96 км замыг хөрөнгөөр бүртгээгүй. 1,786.0 сая төгрөг.
3. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 5: Эмнэлгийн бүсийн 0.58 км замыг хөрөнгөөр бүртгээгүй. 1,313.6 сая төгрөг
4. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 7: Данриг Данжайлин хийдийн баруун урдаас Цагдаагийн газрын баруун талаар хойш явах замын гэрээний дагуу санхүүжүүлсэн дүн 1,596.4 сая төгрөг байхад Дорнод аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Үндсэн хөрөнгө орлогод тухай” 08/09 дүгээр тогтоолын дагуу 1,030.4 сая төгрөгөөр бүртгэсэн байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ” 2.3.1-т Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар: 2.3.1.10-т “төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний **өмч бүртгэл**, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх;”, 4.2.2.4-т “Барилга байгууламж, өргөтгөл, их засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсны үндсэн дээр эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлт гаргах бөгөөд төрийн болон **орон нутгийн өмчид бүртгэх, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх мэдээллийг цахим системд баталгаажуулсан байх;**” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дорнод аймгийн Засаг даргад төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3-т заасан Аймаг, нийслэлийн Засаг даргын чиг үүргийн хүрээнд УТХО-аар санхүүжүүлж, хэрэгжүүлсэн автозамуудыг үндсэн хөрөнгөөр бүртгэж авах ажлыг зохион байгуулах албан шаардлага өгөв.

3.3.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт эрх шилжиж ирсэн автозамын 2 ажил төлөвлөсөн хугацаандаа дуусаагүй 55.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд санхүүжилт татагдсан, ажил зогссон байдалтай байна.

Аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний 9.1 Авто замын сүлжээг өргөтгөнө гэсний 9.1.1 Хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлнэ. 9.1.1.1 Чойбалсан хотын авто замын сүлжээг өргөтгөн шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх /Улсын төсөв -7,947.1 сая төгрөг/, суурь түвшин 65 хувь, зорилтот түвшин 100 хувь гэж тусгасан байна. Гүйцэтгэлээр 7 замын санхүүжилтийг 100 хувь, Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 2 Хүүхэд, эмэгтэйчүүдийн гудамж төслийн 64.3 хувийг, Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 6 Музейн уулзвараас 1800 айлын орон сууц төсөл хүртэлх замын 39.9 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

2025 оны нийт гүйцэтгэл 85.5 хувь буюу зорилтот түвшинд хүрээгүй байна.

УТХО-аар хэрэгжүүлэх замын ажлуудын газар чөлөөлөлтийн асуудлыг бүрэн шийдвэрлэлгүй ажлыг эхлүүлснээр ажил саатаж зураг төслийг өөрчилснөөр гэрээний хугацаанд ажил дуусаагүй. Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамж замын ажлын хувьд гүйцэтгэгч компани ажлыг хуулийн хугацаанд хэрэгжүүлээгүй байна.

1. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын ТЭЗҮ, зураг төслийг батлахдаа автозамын трасс дагуух айлуудын газрыг чөлөөлөх гүйцэтгэлийн явцад хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 6 Музейн уулзвараас 1800 айлын орон сууц хүртэлх замын анхны зураг төсөл дагуух айлуудтай газар чөлөөлөх асуудлаар зөвшилцөлд хүрээгүй учир зураг төслийг өөрчилсөн. Үүнээс шалтгаалан дараах үр дагаврууд үүссэн байна. Үүнд:

- Гэрээгээр байгуулсан хуулийн хугацаанд ажлыг гүйцэтгээгүй.
- Төсөвт жилдээ ажлыг гүйцэтгэж дуусаагүй тул санхүүжилт татагдсан, 2026 оны төсвийн тухай хуульд ажлыг үргэлжлүүлэх санхүүжилт тусгагдаагүй.
- Зураг төсөлд өөрчлөлт орсноор анхны төслийн эцсийн цэг 42 метрээр наашилснаас шалтгаалан 42 метр замд шинээр худалдан авах ажиллагаа зарлахаар болж төсөвт 372.9 сая төгрөгийг тусгасан байна.

2. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 2 Хүүхэд, эмэгтэйчүүдийн гудамж төслийн гүйцэтгэл 64.3 хувийн гүйцэтгэлтэй, үлдэгдэл санхүүжилт татагдсан, 2026 оны төсөвт тусгагдаагүй байгаа нь тухайн зам 2026 онд ашиглалтад орох эсэх нь тодорхойгүй, цаашлаад үнийн өсөлтөөс шалтгаалан төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүсэж байна.

3.3.3 Дорнод аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний Чойбалсан хотын автозамын сүлжээг өргөтгөн шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ төлөвлөсөн бодлогын зорилтот үр дүндээ хүрээгүй байна.

Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 2 Хүүхэд, эмэгтэйчүүдийн гудамж төслийн гүйцэтгэл 64.3 хувийн гүйцэтгэлтэй, Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 6 Музейн уулзвараас шинээр төлөвлөгдөж буй 1800 айлын хотхон, хороолол хүртэлх авто замын гүйцэтгэл 39.9 хувийн гүйцэтгэлтэй зогсонги байдалтай байна.

Дээрх хоёр ажлын санхүүжилтийг Улсын 2026 оны төсөвт тусгагдаагүй байна. Энэ нь тухайн зам ашиглалтад орох эсэх нь тодорхойгүй, цаашлаад үнийн өсөлтөөс шалтгаалан төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг үүсгэж байна.

ҮАГ-ын нэгтгэсэн тайланд ажил нь эхэлсэн ТАХ-г эхэлж санхүүжүүлэхэд чиглүүлж зохион байгуулах, санхүүжилтийг шийдвэрлэж, ажлыг бүрэн дуусгаж байх санал хүргүүлэв.

Захиалагч болон гүйцэтгэгч талуудаас шалтгаалан гэрээний хугацаанд гүйцэтгээгүй ажлын санхүүжилт татагдаж, жил алгасаж санхүүжилт шийдвэрлэгдэж байгаа нь тухайн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэх, ажил зогсох, хөрөнгө оруулалт үр дүнгүй болох нөхцөл байдал үүсэж байна.

Аймгийн Засаг даргад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ажил эхлэхээс дуусах хүртэлх ажлыг хуулийн хугацаанд чанартай гүйцэтгэх иж бүрэн төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөлтийн шаардлага хангасан ТАХ хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

3.3.4 Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн нийцлийн аудитаар хүргүүлсэн аудитын шийдвэр бүрэн хэрэгжээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх “Соёлын төвийн 200 хүний суудалтай барилгын /Дорнод Булан сум/” ажлын гэрээг анх 2021 оны 10 дугаар сарын 18-нд 1,617.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр байгуулсан. Тухайн үед үүссэн ковид цар тахлаас үүдэн ажил зогсож 2023 оны 12 сарын 28-нд гэрээний дүнг 3,270.5 сая төгрөг болгон өсгөж ажил гүйцэтгэх нэмэлт гэрээ байгуулсан байна. Гүйцэтгэлийн явцад гэрээг 4 удаа сунгаж, Булган сумын 200 хүний суудалтай соёлын төвийн барилгыг 2024.12.30-нд хугацааг тулгаж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авснаар эцсийн гүйцэтгэлийн санхүүжилт буцаан татагдсан.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитаар өгсөн шийдвэрийн 83.7 хувь нь хэрэгжээгүй байна.

Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт

Хүснэгт 3.

№	Төсөл, арга хэмжээний нэр	Мөнгөн дүн /сая төгрөг/	Хэрэгжилт	Гүйцэтгэл хувь
1	7 ажлыг урьдчилан санхүүжүүлж, хийж гүйцэтгээгүй 691.0 сая төгрөгийн ажилд гүйцэтгэл бичин илүү санхүүжилт авсан, захиалагчийн хяналтын зардал 12.6 сая төгрөгөөр хэтэрсэн байна. /Албан шаардлага/	703.6	703.6	100%
2	Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/ барилга угсралтын ажлыг хүлээж авахтай холбоотой гэрээнд заасан 288.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлж хүлээлгэн өгөх /Албан шаардлага/	288.1	0	0%
3	Автозамын ажлын төсвийг хянаж үзэхэд төсвийн нормыг буруу хэрэглэн тээврийн зайг буруу тооцоолж алдаа гаргасан, батлагдсан зураг төслийн дагуу хийгээгүйгээс шалтгаалсан 81.5 сая төгрөгийн санхүүжилт илүү авсан байна. /Төлбөрийн акт/	81.5	3.5	0.1
4	Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/ төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон барилга дагалдах тоног төхөөрөмжийг гүйцэтгэгч тал болон ашиглагч талууд хүлээлцсэн акт үйлдээгүй ба хөрөнгөөр бүртгэж аваагүй байна. /Зөвлөмж/	3,270.8	0	0
НИЙТ		4,344.0	707.1	16.3%

Эх сурвалж: Аудиторын дүгнэлт

Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/ барилга угсралтын ажлыг хүлээж авах барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комисс нь 2024 оны 12 дугаар сарын 30-нд тус барилгыг үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авахаар шийдвэр гаргасан боловч үүрэг даалгаврын хэрэгжилтийг газар дээр нь очиж хянаагүй байна.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй Дорнод аймгийн Засаг даргад хариуцлага тооцох албан шаардлага өгөх саналыг МУЕА-т хүргүүлсэн.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4202, факс: 7058-4584
Цахим шуудан: azdtg@domod.gov.mn
Цахим хуудас: Domod.gov.mn

Б. Дамсдорж
Майгариол улсын
аудитын газрын дарга

2026. 05. 07 № 01/105

танай _____ -ны № _____ -т

Б. Болортуул
ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайлангаар ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА *Ш.ЁЛ*



2126070233

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулж, нэн тэргүүнд хэрэгцээ, шаардлагатай төсөл, арга хэмжээг тодорхойлж төлөвлөх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

1.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх автозамын ажлууд гэрээний хугацаандаа хэрэгжээгүй нь газар чөлөөлөлтийн асуудлыг бүрэн шийдвэрлэлгүй төлөвлөж, баталснаас шалтгаалсан байна.

2.1 Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны барилгын гадна шугамын 420.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг сангийн яамнаас хуульд заасан хугацааг хоцроон аймгийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн байна.

2.2 Сангийн яамнаас УТХО-тай холбоотой гарсан 1 гомдлын тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд хянаж, шийдвэрийг цахим сайтад мэдээлсэн байна.

3.1 Автозамын хийгдээгүй 4 ажилд гүйцэтгэл бичиж 379.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

3.2 Хөрөнгө оруулалтын ажлын чанар, гүйцэтгэлтэй холбоотой алдаа, зөрчил гарч байгаа нь захиалагчийн хяналтыг чанартай зохион байгуулж, хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан байна.

3.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 4,658.7 сая төгрөгийн авто замыг санхүүгийн бүртгэл, тайланд тусгаагүй байна.

Аудитаар нийт 5,825.3 сая төгрөгийн зөрчил илэрч 4,704.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1,121.0 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 6 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

Өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй Дорнод аймгийн Засаг даргад хариуцлага тооцох албан шаардлага өгөх саналыг МУЕА-т хүргүүлсэн.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг баталж байх. Мөн орон нутагт хэрэгжих ТАХ-г төлөвлөлтийн шаардлага хангасан эсэхэд онцгой анхаарах.

2. Их засвар, тоног төхөөрөмж ангилалд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль, журамд тусгах.

3. Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах хөрөнгө оруулалтын зураг төсвийн зардлыг баталж байх.

4. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг ТБОНӨХБАУХАТХ-д заасан хугацаанд цахимаар шилжүүлэх.

5. Санхүүжилт авах хүртэл гэрээний хугацаа хүчинтэй байх журамд тусгагдаагүй шаардлага үүсгэж байгаа www.pimis.publicinvestment.gov.mn системд өөрчлөлт оруулах.
6. Ажил нь эхэлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэх.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Дорнод аймгийн Засаг даргад

1. Гүйцэтгэл дутуу багц 2: Хүүхэд, эмэгтэйчүүдийн гудамж, багц 6: Дорнод аймаг, Хэрлэн сумын 3 дугаар баг, аймгийн Музейн уулзвараас шинээр төлөвлөгдөж буй 1800 айлын хотхон, хороолол хүртэлх авто замуудыг бүрэн ашиглалтад оруулах ажлыг шат дараатай зохион байгуулах.
2. Автозамын төсөл, арга хэмжээг чанартай гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах.
3. Автозамын төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг трасс бүхий ажлын эхлэл, төгсгөлд нийтэд харагдахуйц ил тод байршуулах.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ажил эхлэхээс дуусах хүртэлх ажлыг хуулийн хугацаанд чанартай гүйцэтгэх иж бүрэн төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасан.

АЛБАН ШААРДЛАГА:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 01/274

Чойбалсан хот

ДОА-2026/05-9/ШТА-НД

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны "Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/179 дүгээр тушаалыг тус тус үндэслэн "Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд Дорнод аймагт хэрэгжүүлж, улсын комисс хүлээж авсан 4,658.7 сая төгрөгийн дараах замуудыг хөрөнгөөр бүртгээгүй болон зөрүүтэй дүнгээр бүртгэсэн байна. Үүнд:

1. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 3 Содномдаржаагийн гудамжны 0.46км авто замыг хөрөнгөөр бүртгээгүй. /993.1 сая төгрөг./
2. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 4 Хянганы гудамжны 0.96км замыг хөрөнгөөр бүртгээгүй. /1,786.0 сая төгрөг./
3. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 5 Эмнэлгийн бүсийн 0.58км замыг хөрөнгөөр бүртгээгүй. /1,313.6 сая төгрөг./
4. Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ багц 7 Данриг Данжайлин хийдийн баруун урдаас Цагдаагийн газрын баруун талаар хойш явах зам 566.0 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн.

Энэ нь "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.2.2.4-т "барилга байгууламж, өргөтгөл, их засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсны үндсэн дээр эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлт гаргах бөгөөд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх мэдээллийг цахим системд баталгаажуулсан байх", "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1-т "Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2126090988

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1 дэх “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй,” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3-т заасан Аймаг, нийслэлийн Засаг даргын чиг үүргийн хүрээнд Улсын төсвөөс санхүүжүүлж, хэрэгжүүлсэн авто замуудыг үндсэн хөрөнгөөр бүртгэж авах ажлыг зохион байгуулах, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг дарга Ш.Ёл, Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Гэрэлцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 02/275

Чойбалсан хот

ДОА-2026/05-9/ШТА-НА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны "Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/179 дүгээр тушаалыг тус тус үндэслэн "Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвөөр 2025 онд Дорнод аймагт хэрэгжүүлсэн автозамын ажлуудаас үүрэг даалгаврын биелэлтээр авсан ажлуудыг бүрэн гүйцээж хийлгээгүй, хяналт тавиагүй байна. Үүнд:

1. Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/ зам дагуух 221м² явган хүний зам, 120м явган хүний замын хашлага буюу нийт 13.7 сая төгрөгийн ажил.

2. Багц-7 Цагдаагийн газрын баруун талаар хойш 1км үргэлжлэх зам

- Замын төгсгөл хэсэгт 31.9 сая төгрөгийн 80м² явган замын ажил, 2195м² хэвтээ тэмдэглэгээний ажил.
- Замын төгсгөл хэсэгт асфальтбетон хучилт чанарын шаардлага хангаагүй нимгэн дэвссэн, суулт өгсөн, хагарсан. Асфальтбетон хучилтын нягт хүрээгүй дутуу нягтруулсан.
- Хуучин гэрлийн шонгийн нүхийг явган замын хавтангаар дүүргэхээр тусгасан ч газар дээрх хяналтын үед тус ажлыг гүйцэтгээгүй.
- Явган хүний хөтөч хавтанг зургийн дагуу гүйцэтгээгүй.

3. Багц-1 Баянтүмэний гудамжны авто замын борооны ус зайлуулах нүхтэй хашлагуудын нүхний тэгш хэм алдагдсан.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралт "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.2.2-т "Захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэсний 4.2.2.9-т "Төсөл, арга хэмжээний санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн баримт бичиг, иж бүрдэл, түүний үнэн зөв эсэхэд бүрэн хариуцаж ажиллах", 4.4-т "Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг": 4.4.1.5-т "Захиалагчийн техник, технологийн хяналтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу мэргэжлийн түвшинд, чанартай, үр ашигтай, ил тод, нээлттэй болон хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэх", 4.9.2-т "Барилга

2126090991

байгууламжийн чанарын баталгаат хугацаанд Барилгын тухай хуулийн 14.6-д авто замын байгууламжийн тухайд Авто замын тухай хуулийн 28.4-т заасан хугацааг тус тус баримтлах бөгөөд баталгаат хугацаанд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид аливаа доголдол, эвдрэл, гэмтэл гарвал захиалагч нь гүйцэтгэгч байгууллагаар үнэ төлбөргүй, үл маргах журмаар засварлуулж, ашиглалтын хэвийн байдалд оруулах арга хэмжээ авна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан замуудын гүйцэтгээгүй ажлуудыг чанарын хяналтын хугацаанд зөрчлийг арилгаж, төсөл, арга хэмжээг чанартай гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах, биелэлтийг 2026 оны 07 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг дарга Ш.Ёл, Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Гэрэлцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨРСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,  Б.БОЛОРТУУЛ



ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/14

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/175 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газрын дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Батжаргалд даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

2125020048

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2026 оны
5 дугаар сарын 07-ны өдрийн
4/17 дугаар тушаалын хэвсрэлт



Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Албан шаардлагын дүн /сая.төг/
1	Дорнод аймгийн ЗДТГ	01/274 ДОА-2026/05-9/ШТА-НА	4,658.7
2	Дорнод аймгийн ЗДТГ	02/275 ДОА-2026/05-9/ШТА-НА	45.6
Дүн			4.704.3

Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын байр, 4 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn